



Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль

Политехник коллеж

# ИЛТГЭЛ

**Илтгэлийн сэдэв:** Төсөлт хичээлийн үр дүн ба багш оюутны хөгжил

**Илтгэгч:** Эдийн засгийн онол, Бизнесийн удирдлагын магистр /М.Баярмаа/

Говьсүмбэр аймаг

2019 он

## Агуулга

- Түлхүүр үг
- Судалгааны үндэслэл
- Судалгааны ажлын зорилго
- Судалгааны зорилтууд
- Судалгааны арга зүй

## 2 НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ

- 1.1 Төсөлт хичээл гэж юу вэ?
- 1.2 Төсөлт хичээл зорилго, онцлог
- 1.3 Төсөлт хичээлд тавигдах шаардлага
- 1.4 Төсөлт хичээл зохион байгуулах арга, хэлбэр
- 1.5 Төсөлт хичээлийн загвар, үе шат

## 3 ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- 2.1 Төсөлт дипломын судалгаа, түүний үр дүн
- 2.2 Төсөлт дипломыг сонгосон суралцагч болон багшийн хөгжлийн судалгаа
- 2.3 Төсөлт хичээл сургалтыг зохион байгуулж буй сургуулиудын тандах судалгаа
- 2.4 Цаашид хэрэгжүүлэх шинэ санаа

## 4 Дүгнэлт

## 5 Хавсралт

## 6 Ном зүй

## Оршил

Миний бие 2018 оны эрдэм шинжилгээний уралдаанд “Төсөлд хичээлээр суралцагчийг хөгжүүлэх нь” сэдвэтэйгээр амжилттай оролцож байсан билээ. Уг судалгааны ажлыг бичихдээ өөрийн ордог хичээлийг төсөл хэлбэрлүү шилжүүлэн орсноор суралцагчдын хөгжил төлөвшилд хэрхэн нөлөөж буй судлаж байсан. Мөн төгсөгчдийн төгсөлтийн үнэлгээг төсөл хэлбэрээр эсвэл судалгааны ажлаар бичсэн эсэхэд анализ хийн, төсөлт диплом бичсэн суралцагчдын үнэлгээ илүү өндөр байгааг тодруулан гаргасан. Ингэснээр төсөлт хичээл нь аль нэг хэлбэрээр суралцагчдын хөгжил төлөвшилд илүү үр дүнтэй болохыг харуулсан.

Энэ удаагийн илтгэлээ илүү лавшруулан төсөлт дипломыг сонгосон оюутан болон түүнийг удирдан чиглүүлж буй багшийн хөгжилд хэрхэн ахиц дэвшил гарч байгааг судлах цаашлаад манай бүсийн хэмжээнд уг сургалтын аргыг хэрхэн ашигладгийг танадан судалж шинэ санаа дэвшүүлэхийг зорилоо.

### Түлхүүр үг:

- Төсөлт хичээл
- Оюутны хөгжил
- Багшийн хөгжил
- Төсөлт диплом

### Судалгааны үндэслэл:

2015[ - ]2020 онд “Мэргэжлийн боловсрол сургалтын багшийн хөгжил” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажилласан. Уг хөтөлбөрт багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцлийг бүрдүүлэх, багшийн хандлага ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг дэмжих, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжил ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлийг гарган ажилласан бөгөөд энэ онд уг хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх арга хэмжээ явагдаж байна.

Тухайн хөтөлбөрийн хүрээнд багшийн хөгжлийг доорх чиглэлүүдээр авч хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

1. Сурган заах арга зүй
2. Мэргэжлийн ур чадвараа дээшүүлэх
3. Хууль эрх зүйн чиглэлээр
4. Багшийн ёс зүй
5. Ажлын байранд хөгжүүлэх, зайн болон цахим сургалт
6. Багш солилцооны хөтөлбөр
7. Үйлдвэрлэл дээр буюу ажлын байранд
8. Гадаад улсад мэргэжил дээшлүүлсэн

Уг үйл ажиллагааны нэг хэсэг болох багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих гэсэн арга хэмжээг тулгуурлан багш төсөлт хичээлийг сургалтандаа ашиглаж, удирдан чиглүүлж ажилласнаар хэрхэн хөгжиж болохыг нотлон харуулж байна.

### **Судалгааны ажлын зорилго:**

Төсөл хичээл болон төсөлт дипломыг сонгосноор багш оюутан хэрхэн хөгжиж буйг судалж, цаашид хэрэгжүүлэх шинэ санааг дэвшүүлэх

### **Судалгааны зорилтууд:**

- Төсөлт хичээлийн онолын арга зүй
- Төсөлт дипломоор судалгаа хийж төгссөн оюутнууд, түүнийг удирдсан багш нарын хөгжилд судалгаа хийх
- Бүсийн хэмжээнд төсөлт хичээлээр сургалтыг хэрхэн зохион байгуулж буйг судлан шинжлэх
- Судалгааны дүнг нэгтгэн дүгнэж шинэ санаа гаргах

### **Судалгааны арга зүй**

Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализийн аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулахад, ярилцлагын аргыг мэргэжлийн багш нар болон бүсээс судалгаа авч дүгнэлт хийхэд, ажиглалт, ярилцлагын болон тестийн судалгааны аргыг туршилтын явцад суралцагчийн хөгжилд гарч буй өөрчлөлтийг баримтжуулж, нотолгоожуулахад, статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлийг нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийж, боловсруулахад ашиглав.



## НАГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ

Төсөлт хичээл гэж юу вэ?

Швейцарийн сурган хүмүүжүүлэгч Johann Heinrich Pestalozzi 18-р зуунд "Төсөлт хичээл нь сэтгэл зүрх, оюун ухаан, гар биеэр хийх үйл юм" хэмээн төсөлт хичээлийг маш энгийн бөгөөд оновчтой тодорхойлсон нь өнөөгийн төсөлт хичээлийн тодорхойлолтын үндэс болсон байна. Men J. Dewey, W.H.Kilpatrick нар "Нийгмийн тодорхой хүрээнд явагддаг сэтгэл зүрхээрээ гүйцэтгэж буй төлөвлөгөөт үйл ажиллагаа бол төсөлт хичээл юм" гэжээ. Үүнээс харахад суралцагчдын идэвхтэй үйл ажиллагаанд тулгуурласан энэхүү хичээлийн сүүрх хэдийн 18-р зуунд тавигдсан гэж харж болно. Өөрөөр хэлбэл төсөлт хичээлд суралцагчдаас багаар ажиллах чадвар болон өндөр хариуцлага шаардсан, нээлттэй бөгөөд тодорхой сэдвийн хүрээнд явагддаг, эцсийн үр дүнд нь тодорхой бүтээлээр илэрдэг төдийгүй төсөлт ажлын явцад мэдлэг, чадвар эзэмшүүлж байдаг хичээлийн төрөл гэж ойлгож болно.

### 1. Төсөлт хичээл зорилго, онцлог

Төсөлт ажил нь суралцагчдын бие даасан бүтээлч үйл ажиллагааг дээд зэргээр шавхан дайчлаад зорсохгүй амьдралд нь хэрэглэж мэдлэг чадварыг олгож байдагаараа онцлог юм. Иймээс ч энэхүү хичээл нь суралцагчдад:

- Асуудлыг олж харах, дэвшүүлэх чадвар олгох
- Сонирхсон зүйлээ судалж мэдэх нөхцөл бүрдүүлэх
- Сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах чадвар эзэмшүүлэх
- Бие дааж болон хамтран ажиллах чадварт сургах
- Шинэ үүрэг даалгавар гүйцэтгэх стратеги боловсруулж сургах
- Сэтгэл хөдлөлийг дэмжих, сургах сэдэл тэмүүлэл нэмэгдүүлэх
- Мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийх чадварт сургах
- Хувийн зохинон байгуулалт болон өндөр хариуцлага шаарддаг
- Хүүхдийг зөв төлөвшүүлж, илэн далангүй, нээлттэй болгодог.
- Нийгэмтэй харьцах чадвар сургах
- Илтгэх болон хариуцааны чадмаж сургах

### Тарал үүсэл, үндэслэл

Уламжлалт хичээлийн арга зүйд суралцагч багшаас хэт хараат байдагас хувийн хариуцлага суралцагч, сургах идэвх бүрддэг, багшаас мэдээлэл хүлээн аваад хариу үйлдэл үзүүлэхийг нэн тэргүүнд тавьдаг, сургалтын агуулга нь бодит амьдралд холбохгүйгээр цавар онол барьсан, хамтран суралцах болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх талыг орхигдуулсан, хувь хүний онцлог, хэрэгцээ сонирхлыг харгалзан үзэжгүйгээс сургах сэдэл тэмүүлэл бүрддэг гэх зэргээр шүүмжилсээр ирсэн нь одоо ч хэвээр байна.

Энэхүү дутаргалтай талыг засах нэг боломж бол төсөлт хичээлийн арга зүй юм. Суралцагч хэрэгцээ сонирхолдоо нийцүүлэн бие даан асуудал дэвшүүлж



сүрэлцэнээр мэдлэг, чадварын төвшин маш хурдацтай дээшилдэг гэдэг нь хичээлийн бодит туршлагаас харагдаж байна.

**1. Төсөлт хичээлд тавигдах шаардлага**

- Сэдэв нь багш, суралцагсдын сонирхол болон хичээлийн зорилгод нийцсэн байх
- Нийгэм болон хувь хүмүүст тулгамдсан ач холбогдол бүхий сэдэв байх
- Хувь хүнээс өндөр зохион байгуулалт, хариуцлага шаарддаг
- Зорилгод чиглэсэн төлөвлөгөө хийх, бүтээл гарах
- Ахуй амьдралд ойр, бодит нөхцөл байдалд тулгуурласан байх
- Сургалтын орчныг онцлогийг харгалзах
- Багаар болон хамтран суралцахууд чиглэсэн
- Сэтгэл зурх, оюун ухаан, гар биеэр хийж гүйцэтгэдэг
- Ажил хуваарилалт, багийн зохион байгуулалт
- Багш хамтран суралцагч, удирдан чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг

**2. Төсөлт хичээл зохион байгуулах арга, хэлбэр**

Төсөлт хичээлийг олон төрлийн арга, хэлбэрээр явуулж болдог бөгөөд тухайн хичээлийн зорилгоос шалтгаалдаг.

**Хамрах хүрээсэр нь:**

- Орчноор нь:
- Хугацаагаар нь: Нэгж хичээлийн буюу нэг цагийн төсөлт хичээл, сургуулийн орчинд хийгдэх 1 өдрийн, сургуулиас гадурх олон нийтийг хамарсан 7 хоногийн, улирлын төсөлт ажил гэх мэт. Тухайн суралцагчийн нас сэтгэхүйн онцлог, сонгосон сэдвийн агуулгын хүрээ, мэдлэгийн төвшин, судалгаа явуулах орчныг нөхцөл зэргээс хамараад хугацаагаа ямар ч байдлаар төлөвлөж болно.

**3. Төсөлт хичээлийн загвар, үе шат**

Төсөлт хичээлийн арга зүй нь цогц чадвар хөгжүүлэх, өөрийн гэсэн шинж чанартай сурах, сургах үйлийн цогц хэлбэр юм. Төлөвлөгөөгүйгээр төсөлт хичээлийг явуулах боломжгүй гэдэг нь суралцагсдын илэн далангүй байдал болон гэнэтийн тохиолдлоор шийдвэр гаргах зэрэг үян хатан шинж чанар бас төсөлт хичээлийн арга зүйд чухалд тооцогддог байна. Тийм учраас төсөлт хичээлийг төлөвлөх, гүйцэтгэхдээ тухайн үеийн нөхцөл байдал, хүчин зүйлийг харгалзан дүрэм журамд яг тэг баригдах хэрэггүй юм.

Freu (1990)-ийн үзэж буйгаар:

**> Төсөлт хичээл явуулах санаачлага**

Багш, суралцагсдын хэн нэгэн нь сонирхолтой санаа, эсвэл нийгэмд тулгарч буй асуудлыг анги хамт олон дотор дэвшүүлэн тавьснаар төсөлт ажил явуулах анхны сэдэл бий болдог. Сэдэв сонголтыг танхимын цагт багшийн туслалцаатаар хийх нь тохиромжтой бөгөөд багш сэдэв сонголтын үед онцгой мэдрэмжтэй байж суралцагчдын

дэвшүүлж буй сэдвүүдийг аль болох зангидаж, олон ерөнхий сэдэв сонгохоос сэргийлэх хэрэгтэй. Мөн тухайн ерөнхий сэдвийн хүрээнд дотроо, хэт халихгүйгээр "Оюуны зураглал" үүсгэж байгаа эсэхэд хяналт тавина. Тухайн сургалтын байгууллагын онцлогоос хамааран зарим тохиолдолд багш сэдэв сонголтод нөлөөлөхийг үүрэгтэй оролцох хэрэгцээ гардаг. Энэ нь туйлын тохиромжтой биш ч, төсөлт ажил бүтэлгүйтэхээс дээр юм.

Гэхдээ сурлагч ямар багт ажиллах, төсөлт ажлын гүйцэтгэлээ өөрөө шийдэх эрхийг нь олгох нь маш чухал байдаг.

### ➤ Төсөлт ажлын загвар боловсруулах

Энэхүү дэвшүүлсэн асуудалд тулгуурлан төслийн цаашдын үйл явцыг тодорхойлсон загвар боловсруулдаг. Энд цаг төлөвлөлт, баримт мэдээлэл цуглуулах, бодит нотолгоо гаргах, хэрхэн судалгаа явуулахас гадна өөр хоорондоо хэрхэн харилцах, бодит орчинг хэрхэн бүрдүүлэхээ төлөвлөх зэрэг тодорхой дүрэм журам боловсруулж, тохиролцоонд хүрнэ.

### ➤ Төсөлт хичээлийн төлөвлөгөө боловсруулах

Сурлагчид төслийн тайлангаа хэрхэн хамгаалах, дүгнэх хэрхэн судалгаа явуулах, сэдвийн агуулга болон зохион байгуулалтыг нягтгаж үзэх, өөрийн харьцаж буй ажил үүргийн талаар санал болгоо солигцох, явц болон ажлын төлөвлөгөө зохиох, нөхцөл байдлыг тодорхойлон гаргах, танхим, танхимаас гадур зохион байгуулах боломжийг судлах зэргээ бичгээр төлөвлөдөг.

<sup>1</sup> vgl. Emer/ Lenzen, 2002, S.213

### ➤ Төсөлт ажлын гүйцэтгэл

Төслийг төлөвлөгөөний дагуу эхлэнэ. Төсөлт хичээлд багийн гүйцэтгэл чухал байдаг бөгөөд багшийн хяналт, шалгалтгүйгээр нэг зорилготой баг дотроо бие дааж ажиллах чадвар нь төсөлт хичээлийн энгийн хичээлээс ялгагдах онцлог юм. Багаар ажиллах туршлага дутсанаас төсөлт ажил бүтэлгүйтдэг учир нэгж хичээлд багаар ажиллуулах дасгал даалгавар хийлгэх нь хамгийн сайн бэлтгэл болдог.

Төсөлт ажлын туршилт, судалгаанд хэрэглэх арга зөв сонгох нь судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэстэй болгох, асуудлыг олж харах, оновчтой шийдэх боломжийг олгодог.

Сонгосон сэдвээр судалгаа хийхдээ баримт цуглуулах арга (ажиллалт, туршилт, зураглал, асуулга, ярилцлага)-ыг хэрэглэнэ. Ингэхдээ багийн бүх гишүүн биечлэн оролцохыг гол болгох ёстой. Үүний тулд ажил үүргийн хуваарь гарган хугацаагаас нарийн төлөвлөж ажиглана.

### ➤ Багийн ярилцлага

Энэ нь зохион байгууллагын асуудлаа хэлэлцэхээр ярилцах үе шат. Сурлагчид судалж мэдсэнээ баг дотроо ярилцан, төвлөрүүлэх, дараагийн алхмуудаа төлөвлөх,

шинэ санааг дэвшүүлэн тавих, хийсэн ажлын төлөв байдлаа төлөвлөсөн зорилготойгоо харьцуулах, хэсэгчилсэн зорилго, үүрэгт ажлыг шинээр төлөвлөх, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар өөрсдийгөө татах боломжтой.

### ➤ Завсрын тайлан

Завсрын тайлан буюу явц дундын ярилцлага нь зарчмын хувьд багийн ярилцлагаас ялгаатай. Суралцагчид судалж мэдсэнээ бат дотроо ярилцан, нэгтгээд, тайлангийн үед анги дотроо өөр хоорондоо хийсэн ажлаа танилцуулж, дүн шинжилгээ хийнэ.

Завсрын тайлан нь төсөлт ажиглагчид гол үүрэг гүйцэтгэгчид бөгөөд үйл ажиллагааг сурган хүмүүжүүлэх зүйн мэргэжлийн төвшинд хүргэхэд хувь нэмэр оруулдаг байна.

Ер нь багш, явцын буюу завсрын тайлангаар тухайн суралцагч анхны төлөв байдлаасаа хэрхэн өөрчлөгдөж байгааг, өөрөөр хэлбэл тухайн суралцагчийн ахицыг онцгой анзаарч явах учиртай.

### ➤ Төсөл хичээлийн эцсийн тайлан

Төсөлт хичээлийн тайланг 3 үечлэлээр тавина.

### A. Төсөлт ажлын үр дүнг танилцуулах

Төсөлт ажлын үр дүнд эцсийн бүтээгдэхүүн буюу бүтээл гарна. Төсөлт ажлын тайлан хамгаалах олон хэлбэр байдаг байна. Үүнд:

- Үзэсгэлэн, ханын сонин гаргах (performance)
- Фото тайлан, видео бичлэг (mediale)
- Жүжигчилсэн тоглолт (Дүрд тоглох арга), үзүүлбэр, туршилт / szenarische Präsentation
- Зохион бичлэг, ном бүтээх/Dokumentation
- Бүдүүвч хүснэгт, зураглал гаргах

### B. Төсөлт хичээлийн явц, үр дүнгийн үнэлгээ


Төсөлт ажил хичээл хэдийгээр стандарт үнэлгээгээр үнэлэхгүй ч суралцагчийн хөгжил, төлөвшил, ахицыг ямар нэг хэмжээгээр үнэлэх нь гарцаагүй. Суралцагчийн өөрийн үнэлгээ буюу эргэцүүлэмж (portfolio) чухал байдгийг төсөлт ажлын сургалтаар тодорхой туршлага хүрмийгүүлсэн орнуудын жишээ харуулдаг. Гарцхүү өөрийн үнэлгээг хэрхэн тухайд суралцагчийн өөрийнх нь тэмдэглэл. Өөртөө үнэлгээ өгсөн дээрх материалууд нь суралцагчийн бүтээлийн санд байнга хадгалалдаг нь өөрийнхөө алдаа оноог олж харах боломж олгоод зогсохгүй багшид тухайн суралцагчийн ахиц хөгжлийг харах "нээлтэй цонх" болдог. Өөрийн үнэлгээгээс гадна хөндлөнгийн (суралцагч өөрийн болон бусад багийг, багш болон сургуулийн удирдах ажилтнууд, тухайн төсөлт ажилд оролцсон бусад хүмүүс г.м.) үнэлгээг хийж болно.

### B. Үр дүнг баталгаажуулах мөн үрээлжлүүлэх үе шат

Төсөлт хичээлийг нарийвчилж бодитой үнэлэхэд явц дундын тайлан бичих хэрэгтэй байдаг бөгөөд энэ нь бас төслийн явцад дүн шинжилгээ хийх, тодорхой аспектыг сайжруулахад тус дэмтэй байдаг байна.

#### **4. Багш, суралцагсдын чадвар, тавигдах шаардлага**

Төсөлт хичээлийг чанартай зохион байгуулахад багш, суралцагсад тодорхой хэмжээний мэдлэг чадвар эзэмшсэн байх мөн тодорхой шаардлагыг биелүүлэх хэрэгтэй болдог. Багш нь бүтээлч, уян хатан, нээлттэй, төсөлт хичээлийн арга зүйг эзэмшсэн, удирдан чиглүүлэх чадвартай байхын зэрэгцээ суралцагсдын биеэ даасан бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх, хувийн хариуцлагыг ухамсарлуулж, туршлага хуримтлуулахад чиглүүлж дэмжиж өгөх нь чухал байдаг. Төсөлт хичээл амжилттай явуулахад суралцагчаас бүтээлч чанар, багаар ажиллах, зохион байгуулах, хариуцлагаа ухамсарлах, шийдвэр гаргах болон харилцааны чадвар шаарддаг. Эдгээр чадварыг төсөлт хичээл эхлэхээс өмнө тодорхой хэмжээгээр дасгал хийх зэргээр эзэмшүүлж болдог бөгөөд төсөлт хичээлд оролцсоноор улам туршлагажин хөгжиж байдаг.



## ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

*Судалгаа-1:* Төсөлт хичээлээр суралцагчдыг хөгжүүлэн төлөвшүүлэх чиглэлээр 2016 оноос эхлэн туршилт судалгааг хийсэн. Тус оноос өөрийн ордог хичээлийг цогцоор нь төсөл хэлбэрлүү шилжүүлэн орж байсан бол 2018, 2019 онуудад төгсөлтийн ажлыг төсөл хэлбэрээр хамгаалуулснаар суралцагчдад гарах өөрчлөлтүүд цаашлаад уг бүтээлийг удирдан чиглүүлж байгаа багшийн хөгжилд хэрхэн үр нөлөө үзүүлж буйг судлан шинжилж байна. Уг ажлуудын дагуу манай сургуульд 2016 оноос хойш нийт 18 шинэ бүтээл хийгдсэн бөгөөд жил ахих тусам төсөлт дипломын тоо нэмэгдэж байгаа үзүүлэлттэй байна.

	2016 он	2017 он	2018 он	2019 он
Үйлдвэрлэл техникч	3	4	5	1
ХАБ	-	-	1	4
Цахилгаан	-	-	1	2

Энэ тоон үзүүлэлт нь төсөлт дипломын ажил илүү үр дүнтэй байгааг илтгэх бөгөөд уг бүтээлүүдийг хийснээр манай сургуульд доорх давуу талууд бий болж байгаа юм. Үүнд:

1. Сургуулийн онцлог төрхийг илэрхийлсэн бүтээлтэй болсон
2. ҮСД-ын зардлыг үр өгөөжтэй зарцуулсан
3. Багшийн сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, макет, үзүүлэн баяжисан
4. Бүтээлийн үзэсгэлэнг жил бүр зохион байгуулж, аймаг орон нутаг болоод ажил олгогчидод сургуулиа сурталчлах боломж бий болж байгаа
5. Хувийн хэвшилтэй хамтран бүтээлийн эрэлтээ тодорхойлоод төслөө гаргах
6. Бүтээлийн тоог нэмэгдүүлж, өөрийн үйл ажиллагааны орлого олох боломж нэмэгдэх
7. Уг сургалтыг нэвтрүүлсэн анхдагч сургуулийн нэг болсон
8. Чадавхижсан багш оюутантай болсон
9. Эрэлтэд нийцсэн ажилтан бэлтгэн гаргасан

*Судалгаа-2.1: Төсөлт ажлаар дипломоо хамгаалж байсан суралцагчдын суралцаж байх хугацаанд нь DUP (Хөгжлийн давуу чанарын судалдгаа) -аар авсан судалгаа. Мөн төгсөөд ажлын байранд гарсан суралцагчдаас өөрсдийн хөгжилд төсөлт диплом хэрхэн нөлөөлсөн талаарх авсан судалгааг харьцуулан харахад:*


<b>Суралцаж байгаа оюутан</b>	<b>Ажлын байранд гарсан оюутан</b>
Өөртөө итгэлтэй болсон	Ухаж ойлгох чадвар суусан
Асуудлыг олж харах, дэвшүүлэх чадвартай болсон	Ажлын байранд гараад хэрэглэгдэж байсан багаж хэрэгсэл тоног төхөөрөмж ашиглахад хэрэг болсон
Мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх чадварт сургасан	Багаар ажиллах чадвар
Сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах чадвар эзэмшисэн	Мэргэжлийн чиглэлээр илүү их дадлагажсан, өөрийн гараар хийж сурсан
Бусдыг сонсож хэрэгтэй зүйлийг тусгаж авдаг болсон	Хосолсон мэргэжилд илүү дөхөм болсон
Бие даан судалж, судалсан зүйл дээрээ дүгнэлт гаргаж сурсан	Ажлын ярилцлага болон ур чадварын шалгалтанд ороход дөхөм болж байсан
Зөв төлөвшүүлж, илэн далангүй, нээлттэй болсон	Схем холболтууд, унших чадвар сайн суусан ажил дээр гарахад хэрэг болсон
Шинэ үүрэг даалгавар гүйцэтгэх, төлөвлөгөө боловсруулж сурсан	Тооцоолол хэрэг болсон, техник сэтгэлгээтэй болдог.
Мэдээллийг олон сувгаар хайж сурсан	Хувь хүн болон тоног төхөөрөмжтэй ажиллахад их дөхөм болсон
Энэ хичээлээс өөрийн гэсэн зорилготой болсон	Бусдад туслах, хамтарч ажиллах чадвартай болсон
Илтгэх болон харилцааны чадамжтай болсон	Ажлын цагаа сайн баримталдаг, ажил олгогчийн үг тавьсан шаардлагыг биелүүлдэг.
Хувийн зохион байгуулалт болон өндөр хариуцлагатай болсон	Өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь гүйцэтгэдэг.
Бусад хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн	Өөрийн гараар гардаж хийх
Нийгэмтэй харьцах чадвар суулгасан	Практик дээр ажиллах нь ажлын байран дээр гараад илүү ойролцоо
	диплом нь оюутнуудын хувьд илүү үр нөлөөтэй, хамгаалуулсан дээр

*Дээрх судалгаанаас харахад суралцагчид илүү ажил хэрэгч хандлагатай болж, төсөлт дипломын үр нөлөө чухал болохыг ойлгон цаашид төгсөгчдөөс төсөлт ажлаар диплом хамгаалуулах нь үр дүнтэй болохыг онцгойлон анхааруулж хэлж байсан.*




Судалгаа-2.2: Төсөлт дипломыг удирдан чиглүүлэхэд онолын болон мэргэжлийн багш нар ихээхэн оролцоотой байдаг бөгөөд тухайн багшийн заах арга барил, суралцагчидтай ажиллах чиглэл, багшийн өөрийн хөгжилд ихээхэн ахиц дэвшил гардаг бөгөөд харьцуулсан байдлаар доорх судалгааг авлаа.

Онолын багш	Мэргэжлийн багш
✓ Хийх явцад гарч буй асуудлыг даван туулах арга замыг хамтдаа нээн илрүүлэх	
✓ Судалгааны ажлын процессод тавьсан зорилгодоо тууштайгаар хүрэх чадвар буюу эцсийн хариуцлага хүлээх чадварыг төлөвшүүлэх	
✓ Суралцагчдад өөрийгөө өөрчлөх чадварт сургах	
✓ Туршлага хуримтлуулах	
✓ Түншлэгч байгууллагатай холбоо тогтоох, цаашид тууштай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх	
✓ Практик туршилт эрхлэхэд шаардагдах мэргэжлийн тусгай бэлтгэлийг хангаж өгөх	
✓ Хийх явцад гарч буй асуудлыг даван туулах арга замыг хамтдаа нээн илрүүлэх	
✓ Мэргэжлийн мэдлэг ур чадвар сайжрах	✓ Тухайн бүтээлийн талаар өөрөө нарийн мэдлэг эзэмших
✓ Суралцагчийг чиглүүлэх арга зүй сайжрах	✓ Заах арга зүй сайжрах
✓ Судлаач болох	✓ Бүтээл туурвих бүтээлээ патентжуулах
✓ Төслийн баримт бичиг боловсруулах арга зүй сайжрах	✓ Мэргэжлийн ур чадвар нэмэгдэх
✓ Суралцагчдын идэвхи санаачлагыг төрүүлэх сэдэлжүүлэх	✓ Төсөлт дипломыг удирдах явцад суралцагчдын сонгосон бүтээлийн дагуу онолын мэдлэгийг бодит амьдрал дээр туршиж үзэх
✓ Дипломоо хамгаалах арга барилд туслах	✓ Цаг ашиглалт сайжирсан
✓ Төслийн бичвэр болон мэдээлэл боловсруулахад туслалцаа үзүүлэх	✓ Тэвчээртэй байх
✓ Түүхий эд материалын тооцоо хийхэд туслах	✓ Гарын доорх материалыг ашиглах, үнэ бүхий бүтээгдэхүүн гаргах
	✓ Олон талт мэргэжилрүү хөрвөх
	✓ Төсөлд шаардлагатай түүхий эд материалын судалгаа хийх орчинтой танилцах
	✓ Ажлыг сайн төлөвлөж сурсан
	✓ Хэмжилт, тооцооллыг нарийн хийж сурсан
	✓ Дэвшилтэд технолгийг илүү их ашиглах ажиллуулах сонирхолтой болсон

2018, 2019 онуудад төгсөлтийн ажлыг хийж буй оюутнуудад төслийг хэрхэн бэлтгэх талаарх сургалт зохион байгуулсан.








*Төсөлт диплом бичих аргачлал зөвлөмжийг сургуулийн арга зүйч багш болон GIZ төслийн техникийн эксперттэй хамтран боловсруулж туршсан*



*2018, 2019 оны төгсөгчдөд төсөлт ажлаар хэрхэн диплом хамгаалах талаарх арга зүйн сургалтыг зохион байгуулж байгаа нь*

Ур чадварын багш 2015-2018 онуудад төсөлт дипломын удирдагч багш  
нарын чиглүүлж буй байдал



Судалгаа-3: Бүсийн хэмжээнд төсөлт хэлбэрээр диплом болон төгсөлтийн ажлыг удирдан зохион байгуулж буй талаарх тандалт судалгаа

Сургалтын хэлбэр Аймгийн нэрс	Ээлжит хичээл	Курсын ажил бие даалт	Дадлагын тайлан	Төгсөлтийн ажил, диплом
Дорноговь МСҮТ	√	√	√	
Дундговь МСҮТ	√			
Өмнөговь Политехник коллеж	√	√	√	
Бор-Өндөр МСҮТ	√		√	
Налайх МСҮТ	√			
Эрдэнэ МСҮТ				
Говьсүмбэр	√	√	√	√

Дээрх хүснэгтээс харахад бүсийн хэмжээнд төсөлт хичээлийн ач холбогдлыг төдийлөн анхаарахгүй, сургалтын арга төдий хэлбэрээр ашиглаж, тогтсон уламжлалт аргаас салахгүй байна.

Мөн багаар буюу бүлгээр ажиллах хэлбэрийг хичээлд түгээмэл ашигладаг бөгөөд үүнийг төсөлт хичээлтэй андуурах нь судалгаанаас ажиглагдсан. Багийн ажлыг төсөлт хичээлийн нэг хэлбэр гэж үзэж болох боловч цаг хугацаанд хувьд баригдмал явцуу хүрээнд, хэлбэр төдий үйл ажиллагаа болж явагддаг.

Зарим сургуулиудад бие даалт болон дадлагын хичээл дээр төсөлт ажлуудыг тодорхой цагууд дээр хийж гүйцэтгэж байгаа боловч энэ нь ихэвчлэн тухайн багшийн бүтээлч сэтгэлгээ, шинэ санаа болон дайчин шаргуу байдлаас хамаарч байна.

### Судалгааны нэгдсэн дүгнэлт

Төсөлт хичээлийг сонгосноор барш, суралцагчийг хөгжилд дагуулсан хамтын бүтээл болж байгаа бөгөөд энэ нь суралцагчийн хувьд ажил олгогчийн эрэлтэд нийцсэн ажилтан болж, шинийг санаачлагч, үр дүнтэй, идэвхт санаачлагатай, бие даан ажиллаж чаддаг, бүтээмжтэй иргэн болох төлөвшин хөгжиж байна.

Харин баршгийн хувьд төсөлт хичээлээр мэргэжлийн үйл ажиллагаанд тулгуурлан бие даасан үйлдвэр сургалтыг зохион байгуулснаар, оюутны хувийн хөгжлийн олон талт зорилт бүхий чадмжийг бий болгож, үүнийгээ даган ажлын байранд хөгжсөн барш болж чаддаг байна.

### Дэвшүүлж буй шинэ санаа

1. Барш бүр өөрийн орж буй хичээлийн нэг сэдвийг, цаашлаад чадмжийн нэг элемент, нэг нэгжийг төсөл хэлбэрээр зохион байгуулах цаашлаад сургууль бүр дадлагын тайлан, төсөлтийн ажлыг төсөл хэлбэрээр хамгаалуулах
2. Хичээл сургалтын үйл ажиллагаанд төсөлт ажлын ач холбогдлыг ойлгуулан таниулах үйл ажиллагааг эхлүүлэх ( тандаах судалгаа, эрэлтийн тодорхойлох )
3. Төслийн сургалтыг боловсролгүй болгож, бүс, үлс, мэргэжлийн боловсролын салбарын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах
4. Тодорхой нэг төсөл хөтөлбөртэй (GIZ, TMBCC-ыг дэмжих төсөл) хамтран зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх баршын чадавхижуулах сургалтыг зохион байгуулах, үр дүнг дүгнэж, хяналт тавьж ажиглах

## Ном зүй

- “Төсөлт ажлын арга зүй зөвлөмж-1,2,3” УБ, 2009 он
- “Багшлахуйн хөгжил, төсөл ажлын модуль” УБ 2011 он
- Н.Наранцэцэг “Төсөлт ажил цуврал-1” 2011
- Я.Шийлэгмаа “Төсөлт хэлбэрээр хичээл зохион байгуулж орох нь” эрдэм шинжилгээний ажил УБ 2013 он
- Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг “Төсөлт ажил хичээл- Хүүхдийн хөгжил”
- [WWW.GELEGJAMTS.MN](http://WWW.GELEGJAMTS.MN)
- [WWW.GOOGLE.MN](http://WWW.GOOGLE.MN)
- [WWW.BVTEELSURGALT.MN](http://WWW.BVTEELSURGALT.MN)
- [WWW.SLIDESHARE.NET](http://WWW.SLIDESHARE.NET)
- [https://prezi.com/niel\\_fxwectv/presentation/](https://prezi.com/niel_fxwectv/presentation/) Төсөлт ажил-Хүүхэд хөгжил